

МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО УТГА БҮХИЙ ХОРШОО ҮГС  
ХЭЛЦ ЦОГЦОЛБОР БҮТЭЭХ ТУХАЙД

Б.Мөнгөнцэцэг<sup>1</sup>

Сүүлийн үед хэлний утга судлалд ихээхэн анхаарал тавих болсон учраас хэлний түвшин бүрийн нэгжийг ялгахын зэрэгцээ, тэдгээрийн түгээмэл чанарыг анхаарах болсон билээ. Үг хорших нь ойролцоо үг бүтээх нэг эх үүсвэр болох ба С.Ульманн ойролцоо үгс нь утгаараа алгуур ондооших (закон дистрибуции), эсвэл утгаараа ижилсэх (закон притяжения) түгээмэл ёсонд холбогдоно (Ульманн, 1970, 265-266) хэмээн дурдсаны сүүлчийн ёс нь ойролцоо хоршоо үгс болно. Ийнхүү нягтран ижилсэх (концентрация) ёс нь хоршоо үг төдийгүй хэлний бүх түвшдийн нэгж хооронд ч бий болдог байна. Жишээ нь: “ягт- (мөхөх, мухардах, туйлдах, тамирдах, эцэх), шалчийх (хавчийх, нялцайх, доройтох, хулчийх) гэж утгажиж ганцажсан хэлц үг нь “шалчийчихсан хүн, галгүй болсон эр, гал нь буурсан хүн, явцгүй болсон хүн, морь явахиа байсан хүн, хий нь гарчихсан гүзээ, энэ болж эцсэн хонины дэлэн болчихсон, хэмхэрхий араг шиг, хүнээсээ гарсан хүн, хүний тооноос гарсан хүн, шалдаа буусан хүн, хорвоо нь өнгөрсөн хүн, хөсөг нь явчихсан хүн, ир нь мохсон хүн, харьж гүйцсэн эр, больчихсон эр, хорголоо хатаасан амьтан, гууль нь цухуйсан амьтан (Чой.Лувсанжав, 1970, 147) гэсэн хэлц холбоо үг, өгүүлбэртэй утга санаа ойр болох ба нөгөө талдаа “хөгшин хонины насгүй бол-, насны наран хэлбий-, насан зүг бол-, нас дээр гар-, нас өндөр бол-, ханат гэр холдож, хадан гэр ойрт-, эсгий гэрээсээ холдож, энгэр газартаа оч-, эрхтэн бүгд мох-” гэсэн хэлц холбоо үг, өгүүлбэрийн санааг ч агуулж байж болно. Энэ тухайд эрдэмтэн Ц.Сүхбаатар “Ойролцоо утгат үгийг хоршин хэрэглэх нь нэг хэлсэн санааг давтан өгүүлэх биш, харин эхний үгийн илэрхийлсэн ухагдахууны өөр нэг чанарыг нөхөн гаргаж, найруулгыг улам гүйцэт яруу болгодог” (Сүхбаатар, 1988, 102) гэсэн бол эрдэмтэн Д.Бадамдорж “Ойролцоо утгат үг хоршиж, үйл хөдлөлийг улам эрчимжүүлсэн утга илэрхийлнэ. Жишээ нь: өргөх барих, харагдах үзэгдэх, асуух лавлах, уулзах учрах, хонох өнжих, инээх баясах гэх мэт” (Бадамдорж, 1997, 71) гэжээ.

Академич Б.Ринчен “Айл аймаг гэдгийн язгуур нь ай болох тул монголоор бодогч хүн яагаад айл хүн амь нэгтэйгээрээ нэгэн аймаг, нэгэн ай болдог нь сэтгэлд ургаж, айл аймаг гэдэг хоршоо үг, даруй зураачийн дүрсэлсэн зургаас дутуугүй тодоор ашиг сонирхол, амь нэгтэй айл хүнийг айл аймаг гэж хэл нэгтэй, аж төрөн амь зуух байдал нэгтэй, ижил дасал болсон хэсэг бүлэг хүн үзэгдэх мэт санагдах ажээ” (Ринчен, 1967, 2) гэх мэтээр тайлбарласан нь ойролцоо үг бүтэх сэтгэл зүйн талаас буюу хэлэхүүний өнцгөөс үзсэн хэрэг болно. Ингэж нэг үг нь нөгөө үгийн утгыг бүрэн тайлах нь ойролцоо утгатай хоршоо үгнээ тодорхой илэрдэг ажээ. Т.Пагва “амар жаргал, зовлон зүдгүүр, баяр хөөр, сүр живхлан, харгуй зам, цэрэг цуух” (Пагва, 1959,

1. Монгол Улсын Их Сургууль

99) гэх мэт хоршоо үгийг ойролцоо үг гэж үзсэн байдгийг ч дурдаж болох юм. Энэ тухай М.Базаррагчаа “Хоршоо үг нь үндсэндээ ойролцоо ба эсрэг утгад түших тул авианы болоод утгын зохист найруулга цогцлоох эрхэм чухал хэрэглүүр болдог бөгөөд хоршоо үггүйгээр яруу найруулах гэдэг ихэд хомсдох ажээ (Базаррагчаа, 1990, 37) гэж тэмдэглэн, Б. Ринчений “Сандо амбан” (Уб.,1973), Лувсанданзаны “Алтан товч” (Уб.,1957) зохиолын ойролцоо хоршоо үгийг 9 ангилан үзсэн байна.

Тогоо “аюул - түгшүүр; уур - хилэн; хорсол - занал; хүсэл - эрмэлзэл; зуршил - заншил; хэрэг - явдал; гэрч - баримт; эргүүл - чаараг; алс - хол; ядуу - зүдүү; өнөд - мөнх; алгуур - аажим; бодох - санах; арвилах - гамнах; эрхлэх - эзэгнэх; мөхөх - сонөх; балай - мунхаг; шатаах - түлэх; авир - овор; сэцэн - сэргэлэн” (Тогоо, 1993, 720) гэх мэт ойролцоо үгийг иш татсан нь хоршоо үг болох ба Ю.Д.Апресяны үзсэнээр эдгээрийн нэг нь нөгөөгөө тайлбарласан үг болох ажээ (Апресян, 1999, стр. XXXII).

Академич Б.Ринчен ойролцоо үгсийг хоршин хэрэглэхээс гадна, хос мөр бүтээдэг учрыг аман ба бичгийн хэлний жишээгээр харуулснаас ганц хоёрыг дурдвал,

“Анчин гөрөөчин, авчин шувуучин

Шагайчин харвуулчин нийгэм бүхийгээр

Найр их цэнгэлд авцарья гэж хэлжээ.

Үхсэнийг мөрөөр үлдэж явсан

Хатсаныг мөрөөр хайж явсан

Зан муутын үр

Заяа муутын үхин гэшиб.

Санасан юмыг нь бүтээж хайрлагтуй

Сарвайсин юмыг нь тусалж хайрлагтуй (Ринчен, 1967, 69-70) гэхэд “анчин гөрөөчин (авчин шувуучин), шагайчин харвуулчин” найр цэнгэл гэсэн ойролцоо үгийг хоршсон бол “зан, санасан” хэмээх үгнээ дүрслэг утга бүхий “заяа, сарвайсин” хэмээх үгийг хоршсоныг хоёр мөр өгүүлбэр болгон толгой холбосон нь найруулгын нэг ур маяг болжээ. Мөн тэрээр “... зэрэгцэл байдлаар хэрэглэдэг хоршоо үг, тус тусдаа салаад, зэрэгцэл зүйр үгийн зүйл болж, үг найруулгад зэрэгцэл байдалтайгаар хэрэглэх нь цөөнгүй, ялангуяа туульсын найруулгад энэ тэр, чимэг хавсарсан зэрэгцэл үгийн байдалтай байдаг нь:

“Хүн төөрөм хүдэн

Мал төөрөм манан” гэх манан хүдэн, хүдэн манан гэдэг хоршоо үгийг дэлгэрүүлэн зэрэгцэл үг шүлэг болгосон лугаа адил жишээ олон байдаг байна” гээд, эл үзэгдэл монгол хэлтэн ардын аль ч аман аялгуунд байдаг болохыг дурджээ. Харин Ж.Төмөрцэрэн “ойролцоо үгээр шүлгийн шад бүтээнэ” гээд,

Ардын цэрэг хил хязгаарт сууж,

Өдөр шонөгүй манана.

Цусны цэрэг судлын амсар сахиж

Агиин хоромгүй сахина. (Д. Нацагдорж)

гэхэд “хил хязгаар”, “агиин хором” гэсэн ойролцоо хоршоо үгийг хэрэглэсэн бол

“Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар

Үр ач бидний үржиж өссөн орон


Таван хошуу мал тал дүүрэн бэлчсэн нутаг

Монгол хүн бидний сэтгэлийг сорсон орон (Д. Нацагдорж)


гэхэд “газар-орон-нутаг” гэсэн ойролцоо үгийг салгаж, мөрүүдийг ойролцоо үгээр зангидсан байна (Төмөрцэрэн, 1964, 1974, 38-39) гэжээ. Энэ тухайд эрдэмтэн М.Базаррагчаа “Хоршоо үг нь үндсэндээ ойролцоо ба эсрэг утгад түших тул авианы болоод утгын зохист найруулга цогцлоох эрхэм чухал хэрэглүүр болдог бөгөөд хоршоо үггүйгээр яруу найруулах гэдэг ихэд хомсдох ажээ. ... Монгол хэлний эсрэг ба ойролцоо үг нь нийлэхээрээ хоршоо үг, салахаараа

Б.Мөнгөнцэцэг

өгүүлбэрийн зэрэгцэл бүтээдэг байна” (Базаррагчаа, 1990, 37) гэжээ. Энэ бүхнээс давтах, хорших шинжийг дараах байдлаар загварчилж болох юм. Үүнд:



Хэлэнд агуулга ба гаргалгын тал бүхий эх, өгүүлбэр, үг, бүтээвэр гэсэн үндсэн нэгжүүд байдаг. Хэлний дээд, доод түвшин, тэдгээрийн нэгжүүдийн багтах, багтаах эрэмбэ дэс нь тухайн хэлний нэгжүүдийн хувьд шаталсан тогтолцоог бүрдүүлнэ. Эдгээр нэгжүүд нь үүрэг мөн чанараараа бие биеэ нөхөхийн зэрэгцээ бие биетэйгээ эсрэгцэн, дээд түвшний нэгж нь доод түвшнийхээ нэгжийг багтааж, доод түвшний нэгж нь урвуугаар дээд түвшнийхээ нэгжид багтдаг байна. Хэлний нэгжүүд ийнхүү давхарлан шаталсан тогтолцоог үүсгэхдээ ойролцоо ба эсрэг, төсөөт ба зүйлчилсэн утгатай байна. Хэлний нэгжүүдийн хоорондох утгын гол харьцаа нь хэлний түвшин бүрийн нэгжид түгээмэл тохиолдох учраас



гэж загварчилж болох юм.

Ертөнцийн явдлыг хураан багтаасан хэлц цогцолбор нь ихэвчлэн хос мөрөөс бүтэхийн зэрэгцээ үг, өгүүлбэрийн хоорондох завсрын түвшний нэгж болох хоршоо үгтэй адил бөгөөд түүнээс эхтэй юм. Хэлний бага нэгж нь их нэгжээ агуулдаг, их нэгж нь бага нэгжээ багтаадаг харьцаанд нь тулгуурлан, монгол хэлний ойролцоо хэлц цогцолборыг завсрын түвшний нэгж

Б.Мөнгөнцэцэг

болох ойролцоо хоршоо үгтэй нь харгалдуулан үзэж болохыг жишээгээр тодруулъя.

*Ачийг ачаар*

*Уургүй номхон*

*Тусыг тусаар*

*Уцааргүй дөлгөөн*

*Мангууд түрүүгүй*

*Сандрахад саад олон*

*Тэнэгт тэргүүнгүй*

*Яарихад яришиг олон*

гэхэд “ач – тус, тэнэг – мангуу, тэргүүн – түрүү, уур – уцаар, номхон – дөлгөөн, яарах – сандрах, саад – яришиг” зэрэг ойролцоо хоршоо үгс нь хос мөрөнд зэрэгцэн, ойролцоо хэлц цогцолборыг бүтээжээ. Гэтэл “завхай зайдан, нөхөр сүүдэр, түргэн түүхий, уйлах унжих, санах сарвайх, харах хаацайлах, шунах шудах, хэрүүл шуугиан, мандах бадрах, үхэх хатах, хайр гам, гал голомт, өдөр судар, удам судар, тохоох тамилох, атаа хор” гэхэд адилтгалаар. “сав сааль, хэл ам, гал тогоо, мод толгой (соруулгүй гаанс), түүх шастир, ортоо улаа” зэрэг нь орлолоор бүтэхийн зэрэгцээ үгийн сангийн утгаараа өөр хэдий ч ойролцоо хоршоо үгс болно. Тодруулбал, “хэл ам” гэхэд “үг яриа”-г өгүүлдэгч эрхтнээр нь солин нэрлэж, орлолоор бүтсэн ойролцоо хоршоо үг юм. Харин “уях-сойх” гэсэн хоршоо үгийг авч үзье. “зангидах, бэхлэх, тогтоох” гэсэн утгатай “уях” гэсэн үг нь “алив юмыг хязгаарлах, тогтоох” гэсэн утгатай “сойх” хэмээх үгтэй хоршиж, улмаар “морь уралдуулахаар засах” гэсэн утгаар ижилсэн, адилтгалаар бүтсэн байна. Энэ нь хэлэхүүний талаас дүрслэх ур маягаар үүссэн ойролцоо хэлц цогцолбор бүтээх эх булаг болдог гэж үзэж болно. Жишээ нь:

*Арсланг барихад аргаар*

*Гэр гэрийн шуугиан*

*Адууг барихад уургаар*

*Гэдэс гүзээний дулаан*

*Айсан хүн ам алддаг*

*Өөдлөх айлын үг нь нэг*

*Эцсэн чоно чацга алддаг*

*Өсөх малын зүс нь нэг*

Гэхэд “арслан – адуу, арга – уурга, айх – эцэх, хүн – чоно, ам – чацга, гэр гэр – гэдэс гүзээ, шуугиан – дулаан, өөдлөх – өсөх, айл – мал, үг – зүс” гэх мэт ойролцоо бус үгс эн зэрэгцсэн хэдий ч илтгэж буй санаагаараа ижилсэн, ойролцоо хэлц цогцолбор бүтээсэн байна. Өөрөөр хэлбэл, дүрслэх ур маягаар ойролцоо санаа бүхий хэлц цогцолбор бүтээжээ.

	<u>болит буюу юмжуулах харьцаа</u> /адилтгал, орлолоор бүтээгүй/	<u>хийсвэр буюу дохиожуулах харьцаа</u> /адилтгал, орлолоор бүтээн/
ойролцоо хоршоо үг	хаан- эзэн, ээлж- халаа, бороо- хур, болзоо- хугацаа, зовох- ядрах, нохор- янаг, чанар- тар, танигд- мэдэгд-	өсөх <u>өндийх</u> , <u>өргөх</u> дэмжих, салах <u>сарних</u> , <u>хөл үймээн</u> , <u>сав сааль</u> , <u>гуйх гувших</u> , <u>хавчих</u> <u>хайрах</u> , хөнгөн <u>шингэн</u> , унан <u>тусан</u> , <u>ихэс</u> <u>сайд</u> , <u>мөнгө зоос</u> , <u>олз омог</u> , <u>сул амар</u> , <u>хатуу</u> чийрэг, <u>хатуу ширүүн</u> , <u>цэцэн хури</u>
ойролцоо хэлц цогцолбор	<i>Хааны алба халаатай</i> <i>Эзний алба ээлжтэй</i> <i>Бороотой боловч болзоондоо</i> <i>Хуртай боловч хугацаандаа</i> <i>Зовох цагт нохрийн чанар мэдэгдэнэ</i> <i>Ядрах цагт янагийн тар танигдана</i>	<i>Баригдаагүй загасны бараа нь их</i> <i>Бариагүй гэрийн унь урт</i> <i>Үхэр алаад сүүлэн дээр нь</i> <i>Хутгаа хугацах</i> <i>Үг хэлээд утган дээр нь</i> <i>Хэл хальтрах</i>

Одоо дээр өгүүлсэн зүйлтэй уялдуулж зарим нэг жишээ авч үзье.

Ухаан (хүний дээд хэмжээгээр хийсвэрлэн сэтгэх чадвар: ухаан ихтэй) хэмээх үг нь

I. арга, хүний тархины сэтгэх явц (ухаан гаргах/ заах/ зарах/ сийлэх/ сэлбэх/ хэрэглэх, ухааныг нь олох/ үзэх, бүдүүн/ нарийн/ хар ухаан)

II. судлал, сургаал, шинжлэл, онол (анагаах ухаан, гүн ухаан, хувилахуй ухаан)

III. учир, шалтгаан (ухааныг нь олох)<sup>2</sup> гэсэн салаа утгатай бөгөөд (I) Санаа, Билиг, Бодол, Мэдрэл, Сэхээ, Тамир, Мэдлэг, Мэдээ, Мэдэц, Арга, Ой, Онол, Оюун зэрэг үгтэй үгийнсан-утгазүйн нэг оронд багтаж,

а. - ухаан санаа (хүний эрүүл саруул сэтгэлгээ)

-ухаан билиг (хүний сэтгэлгээний чадвар)

-ухаан бодол (санаа бодол)

-ухаан сэхээ (авхаалж самбаа, санаа бодол)

-ухаан тамир (ухаан бодол, тамир тэнхээ)

-ухаан мэдрэл (хүний бодот ертөнцийг мэдрэх чадвар)

-ухаан мэдлэг (хүний боловсрол болон хийсвэрлэн бодох чадвар)

-ухаан мэдээ (бүх уураг тархи болон бусад эд эрхтний эрүүл үйл ажиллагаа)

-ухаан сэхээгүй (а.өөрийн мэдэлгүй; б.ухвар мэдлэггүй, юм үзэж сураагүй)

б. -мэдэц ухаан (хэрэг явдлын учир зүйг ухаан ойлгох чадвар)

-арга ухаан (юмыг хийх эв дүй, сэтгэх чадвар)

-ой ухаан (юмс үзэгдлийг таньж мэдэх, ухаарч ойлгох, тогтоож цээжлэх чадвар)

-онол ухаан (байгаль ертөнц хийгээд нийгэм сэтгэхүйн тухай системийн дүгнэлт)

-оюун ухаан (юмс үзэгдлийг танин мэдэх, нэгтгэн дүгнэх оюуны үйл ажиллагаа, ойлгож ухаарах чадвар)

гэх мэтээр хоршин хэрэглэгддэг. Эдгээрээс “ухаан санаа” гэсэн ойролцоо утга бүхий хоршоо үг нь хэрхэн ойролцоо хэлц цогцолбор бүтээх тухайд тодруулъя.

“Хүний эрүүл саруул ухаан, тархи толгойны ажиллах чадвар” гэсэн утга бүхий “ухаан санаа” гэх хоршоо үг нь хос мөрөнд зэрэгцэн бүтээн

“Ухаан нь ууцандаа

Санаа нь сүүжиндээ

Ухаанд нь ухна ухсэн

2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбаргүй толь, IV боть, Уб., 2008, 2267- 2268 т.

*Санаанд нь сарлаг үхсэн*

*Ухаанд нь ус орж*

*Санаанд нь шавар орох*

*Ухааныг уяж болохгүй*

*Санааг савлаж болохгүй*" зэрэгт "ууц-сүүж (хүний зүйл), ухна-сарлаг (амьтны зүйл), ус-шавар (гараг ертөнцийн зүйл)" гэх мэт ойролцоо бус зүйлийн үгс эн зэрэгцсэн хэдий ч илтгэж буй санаагаараа ижилсэн, хэлц цогцолбор бүтээсэн байна. Одоо эдгээр зүйлийн үгсийг сонгосны учрыг монгол сэтгэлгээний онцлог талаас нь харьцуулан ажиглая.

Юмыг ухаарч ойлгохгүй хүнийг "Ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ" гэж хэлнэ. Монгол хүний ухаарлаар ухаан нь хөндий, уудам талбай бүхий цээжин дотор үргэлж чөлөөтэй хөдөлж, гүйлгээ ухаан суух ёстой атал үүнийг биенийн хэсэгтэй харьцуулахад бүхэл цул биеийн хэсэг болох "ууц (нурууны сээрээс хойш ахар сүүл хүртэлх хэсэг, харцага), сүүж (хүн, амьтны гуяны дунд чөмөгний дээд этгээдэд ууцтай холболдон байдаг нүхтэй яс)"-нд ухаан орох юм бол мулгуу тэнэг болох мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлдэг онцлог тодорно. Хүн, амьтны бэлхүүс, хүзүү хоёрын хоорондох хэсгийг цээж гэх бөгөөд *цээжний хөндий* (өрцнөөс дээших хөндий, хэнхдэг), *цээжний хэнгэрцэг* (өвчүү, хавирга, сээрний яснаас бүрдсэн шоовон хэлбэртэй ясан хайрцаг) гэх нь бий. Монгол хүн цээжийг "багтаамжтай" гэсэн утгаар ойлгодог, аливаа зүйлийн учрыг олсондоо баярлахын сацуу уужирч тайвширдаг. Ийм ч учраас "цээж уужрах (а.цээж дүүрэхээ болих, б.сэтгэл санаа тайвшрах), цээж онгойх (ухаан санаа уужрах), цээж тэнийх (сэтгэлийн зовлон дарамт арилах), цээж зудлах (санасан бодсоноо нуулгүй, бүгдийг ярих, хэлэх), цээж сайтай (хүний оюун ухаан хурц, сэргэлэн, юмыг мартдаггүй), цээж ихтэй (үзсэн сонссоноо мартдаггүй хүн; цээжтэй), цээж саруул (ухаан санаа, ухаан бодол уужуу), цээж дүрэн (сэтгэл санаа баясгалантай), цээжээр бичих (бодсон санасан, тогтоосон зүйлээ бичих), цээжээ хавтаслах (ном эрдэмтэй болох, ном зохиол их уншиж мэдлэгтэй болох), цээжийн бөх (ухаантай; мэргэн цэцэн); эр хүний цээжинд; эмэгтэйд хязгаартай мөрб бэртэй (эр хүний ухаан бодол уужуу) гэхээс гадна цээж муутай (юм тогтоохдоо муу), хөндий цээж (юу ч мэдэхгүй мөртлөө мэдэмхийрдэг, бардам сагсуу), цээж түрэх - цээж тэлэх (а.цээжээ урагш болгох, б.омгорхог зан ааш гаргах, ханхалзах), цээжнийхээ махыг барж идэх (сэтгэл туйлын их зовох), аавын цээж (хаахгар, их зантай, давилуун хөвгүүн), аавын цээж гаргах (нас бага хүүхэд, хаахгар, давилуун зан гаргах)" гэж сөргөөр хэлэх нь ч бий.

Монгол хүний үзлээр ухааныг хөндий, уужим зай бүхий цээжин дотор үргэлж бясалгаж хөдөлгөж байх ёстой атал тэрхүү хөдөлгөөнийг хязгаарлах юм бол мулгуу тэнэг болох мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлдэг онцлог нь "Ухааныг уяж болохгүй, санааг савлаж болохгүй" гэсэн хэллэгээр илэрч байна.

Монголчууд "Ухаанд нь ухна үхсэн, санаанд нь сарлаг үхсэн" гэж хэлдэг. Гэтэл хамгийн сайн мэдэх малаасаа тэмээг биш, ямааг биш яагаад заавал ухна (хөнгөлж засаагүй эр ямаа), сарлаг (хүзүү, дөрвөн мөч охор, сээр өндөр, урт үстэй нэг зүйл үхэр)-ийг сонгов? Учир нь монгол хүн ухныг дараах байдлаар ойлгодог ажээ. Үүнд:

- ухна царайлах (уруу царайлах, ухнагүй байх)
- халтар ухна (бохир завиан)
- халтар ухна болох (бохиртох, завиан болох)
- Ухна шиг эс аашлах аашгүй
- Улиг хүн эс загнах зангүй
- Ухна шиг бүү бавтна
- Буур шиг бүү галзуур
- Ухнын бие нь үзэгдэхгүй заар нь ханхлах
- Уришгтын бие нь харагдахгүй зар нь хангинах
- Баруун зүгийн бам хар тангад

*Загал хошуутай, зааран хормойтой*

*Зай завсаргүй тарнидна (Ухна)*

- *Дээрээ хоёр жадтай, доороо хоёр домботой*
- Аймаар хурц нүдтэй, анхил ханхил үнэртэй (Ухна)*
- *Урт шар илдтэй, уранхай навтас дээлтэй*

*Унжуу цагаан сахалтай, үглүүр бавтнуур заарт (Ухна)*

зэргээс үзвэл, ухнын дүр зураг нь үзэх нүднээ сүр их, навсайж нэвсийсэн, заар зангаг ханхалсан амьтан байдаг ажээ. Ийнхүү хөндий, уужим зай бүхий цээж буюу ухаанд нь хэжим (гэдэсний дагуу ургасан урт үс), саваг үс (сарлагийн хэжлүүрийг дагаж ургасан болон биеийн бусад хэсгийн үс) ихтэй, газартай үргэлжлэн ороолдсон, нэвсгэр том амьтан (ухна, сарлаг) ороод үхсэнтэй адилтгаж хэтрүүлсэн нь уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон) болсон ухна, сарлагийн гадаад дүрийн төстэй шинжид тулгуурлажээ. Энэ нь монголчуудын сэтгэхүйн өвөрмөц дүр зураг болжээ.

“Ухаанд нь ус орж, санаанд нь шавар орох” гэсэн хэлцийн тухайд, уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон)-ээр ус, шаврыг сонгосон нь малыг амьжиргааныхаа эх үндэс болгож ирсэн монголчууд хамгийн сайн мэдэх цагаан идээтэйгээ холбож, усыг шимгүй, сүүг шимтэй хэмээн эсрэгцүүлэн үздэгтэй холбоотой аж. Энэ мэтээс үүдэж *усан тэнэг* (юу ч мэдэхгүй, туйлын мангуу), *усан толгой* (мангуу), *усан нүдлэх* (уйлах), *усан нүдэт* (уйланхай), *усан гүзээ болох* (шалба норох, нэвт норох), *усан чодор* (цай нь болохгүй хүлээлгэх), *усан амтай* (дандаа бүтэлгүй юм ярьж явдаг), *ус болох* (хор болох, саад болох), *ус балгасан юм шиг* (үг дуугарч чадахгүй гөлөлзөх, яахаа мэдэхээ болих), *гал ус хоёр шиг* (хоорондоо харшилдсан, огт таарч тохирохгүй), *олгойтой ус шиг* (эв хавгүй, хэлбэр галбир муутай) гэх мэтчилэн сөргөөр хэлэх нь олонтоо байна. Харин сүүт шимтэй хэмээн эрхэмлэдгийн нлрэл нь *сүү шиг дотортой* (цагаан санаатай, сайхан сэтгэлтэй), *сүүний хариу цус* (ачийг өшөөгөөр, сайныг муугаар хариулах), *сүүтэй л бол эх* (биед нь ашигтай л бол сайн), *сүү мэт цагаан сэтгэлтэй, түлхүүр мэт уран гартай* (сэтгэл сайхан, ажилд чадамгай), *сүүн мөртэй* (сайн, бэлгэшээлтэй), *сүүгүй цай хар, сүсэггүй сэтгэл хар* (хүн итгэх бишрэх юмгүй, айж ичих зүйлгүй байх нь муу), *сүү хийсэн савнаас үнэр нь гарахгүй, сур иддэг нохойны ховдог нь гарахгүй* (сурсан занг болиход хэцүү), *сүү гашилбал язмаг, мэргэд ганцаардвал ончин* (хань нөхөр, ах дүүгүй ганцаардах хэцүү) зэрэг хэллэгээс тодорхой харагдаж байна. “Гэхдээ энэ нь монгол хүн усыг хэрэггүй, тусгүй зүйл гэж үздэг гэсэн үг биш, харин ч “Амьдралыг тэтгэгч гурван чандмань эрдэнийн нэг нь ус мөн” гэж ардын үлгэр домогт гардаг. Гагцхүү сүүтэй харьцуулсан үнэлэмжээс л харшууллын энэ утга санаа үүсэх болсныг тэмдэглэх хэрэгтэй болсон юмаа”.<sup>3</sup> Иймд ус, сүү хоёр бол шимтэй-шимгүй эсрэгцлийн жишиг хэмжүүр болж тогтжээ.

Аль ч үндэстэн ертөнцийг таних өөр өөрийн арга, хэв маягтай. Үүний нэг нь эх хэл, түүнд байдаг хэлц нэгж юм. “Энэ нь тухайн соёл-хэлт үндэстний эртнээс нааш аж төрж ирсэн нутаг орон, түүний байгалийн байдал, эрхэлж ирсэн аж ахуй, аж төрөх ёс буюу амьдралын хэв маяг, ёс заншил, шашин шүтлэг, тэргүүтний өвөрмөц онцлогоос үүдэж, тухайн юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдал зэргийг үнэлэх үнэлэмжийн жишиг хэмжүүр (etalon)-ийг бий болгосон байдагтай холбоотой ажээ. Эдгээр нь тухайн үндэстний сэтгэлгээний хэв шинж (stereotype)-ийг тодорхойлох гэрч баримт болдог байна”<sup>4</sup>.

Хэлний бага нэгж нь их нэгжээ агуулдаг, их нэгж нь бага нэгжээ багтаадаг харьцаанд нь тулгуурлан, монгол хэлний ойролцоо хэлц цогцолборыг завсрын түвшний нэгж болох ойролцоо хоршоо үгтэй нь харгалдуулан үзэж болохын зэрэгцээ тэдгээрт илрэх монгол ухаан, монгол сэтгэлгээний өвөрмөц онцлогийг зарим жишээгээр тодруулах гэж оролдлоо.

3. Ж.Баянсан. Хэл, соёл, сэтгэлгээ. Уб., 2002, 7 т.

4. Ж.Баянсан. Хэл, соёл, сэтгэлгээ. Уб., 2002, 2 т.

Эцэст нь дүгнэхэд, ойролцоо үгийн утга нийлэх буюу ижилсэн саармагшиж хоршоо үг бүтэх ба харин салах буюу ондоошин ялгарахаараа утга, хэлбэрээрээ эн зэрэгцсэн хэлц цогцолбор бүтдэг байна. Тодруулбал, монгол хэлний ойролцоо хэлц цогцолборыг ойролцоо утга бүхий хоршоо үгээс үүдэлтэй гэж үзэж болно. Ойролцоо утгат хоршоо үгийн утгын болон авианы ойролцоо байдлыг харгалзан толгой сүүл холбон, мөр тэгшитгэн нэг дор эгнүүлэхээс гадна мөр алгасан салаавчлах байдлаар мөр бадаг тэнцүүлж, улмаар мөр мөрт салган зэрэгцүүлсэн нь олонтоо байна.

## НОМ ЗҮЙ

- Апресян.Ю.Д. Новый объяснительный словарь синонимов русского языка. Первый выпуск. М., 1999
- Бадамдорж.Д. Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс. Уб., 1997
- Базаррагчаа.М. Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд. Уб., 1990
- Баянсан.Ж. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ. Уб., 2002
- Лувсанжав.Чой. Орос - монгол өвөрмөц хэллэгийн толь. Уб., 1970
- Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбаргүй толь. Уб., 2008
- Пагва.Т. Хэлний шинжлэлийн удиртгал. Уб., 1959
- Ринчен.Б. Монгол бичгийн хэлний зүй. Өгүүлбэр зүй, дөтгөөр дэвтэр. Уб., 1967
- Сүхбаатар.Ц. Монгол хэлний найруулга зүй. Уб., 1988 (1998, 2002, 2004, 2007, 2009)
- Тогоо. Үгийн сангийн зүй. *Орчин үеийн монгол хэл*. Хөх хот, 1993, 1996
- Төмөрцэрэн.Ж. Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн судлал. Уб., 1964 (1974, 2001)
- Ульман.С. Семантические универсалии. *Новое в лингвистике*. Вып. V. (Языковые универсалии). М., 1970

## RESUME

Based on the relation which big units language includes the small ones while bigger parts includes smaller, we tried to show the synonymous phrasal expression how can be compared with the synonym phrases as the intermediate unit. Mongolian mind can express and it's features in them. Synonyms make compound nouns when their meaning is similar or same, but when it has become different according to their meaning make phrasal expressions which have the parallel meaning and type. To clarify, we can say that Mongolian phrasal expression is originated from the byword which has the similar meaning. Providing synonymous bywords phonetic and meaning used heading and ending combined, lines are equalized, passed the lines and parallelized to each lines separately.